

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд:

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хувьд:

Дэд хөтөлбөрийн 5.4 тэрбум төгрөгийн дөрөв дахь зээлийн шугамыг Хаан банкинд 1 жилийн хугацаатайгаар 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нээж, ҮХААЯ-аас сонгогдсон нөөцийн менежер болох “Эрдмийт” ХХК уг эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглаж эхлээд байна. Ингэснээр махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанкнаас бүрэн олгож дуусаад байна.

“Гурилын нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:

ҮХААЯ-аас гурилын үйлдвэрүүдийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулаад байгаа бөгөөд Монголбанкнаас банкуудтай гэрээ байгуулах шатанд явж байна.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү. <http://www.mongolbank.mn/pricestability.aspx>